



ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ
ДАРГА
Д.ЦОГТБААТАР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.03.25 № 03/97 УАГ-САГ/2013/65-СТА-ТОВГ

ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТУХАЙ

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Дулаан шарын гол” ТӨХК-ий 2012 оны санхүүгийн тайланд аудит хийлээ.

ТӨХ-ны 2009 оны 433 дугаар тогтоолоор “Дулаан Шарын гол” ТӨХК-аас “Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК-д төлөх цахилгааны үнэ 200.0 сая төгрөгийг “Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК-иас “Төвийн бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ХК-д, “Төвийн бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ” ХК-иас “Дарханы Цахилгаан станц” ХК-д, “Дарханы цахилгаан станц” ХК-иас “Багануур” ХК-д дамжуулан суутган тооцох замаар өглөгийг хаах шийдвэр гарсныг “Дулаан Шарын гол” ТӨХК хааж данс бүртгэлд тусгасан боловч “Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК хаагаагүйгээс өр авлагын үлдэгдэлтэй тайлагнагдсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2-д “санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх;” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих” гэж заасныг үндэслэн дээрх зөрчлийг арилгаж, гүйцэтгэлийг гарган 2013 оны 7 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг тус ТӨХ-ны Бүртгэл ашиглалт, хяналтын газрын мэргэжилтэн Л.Сэлэнгэ, Дулаан шарын гол” ТӨХК-ий захирал Б.Энхцэцэг, ерөнхий нягтлан бодогч П.Сүнжидмаа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР**

**СИ ЭС АЙ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ**

ЗӨВШӨӨРСӨН:

“ДУЛААН ШАРЫН ГОЛ” ТӨХК-ИЙН ЗАХИРАЛ

“ДУЛААН ШАРЫН ГОЛ” ТӨХК-ИЙН ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

Л.ОДГЭРЭЛ

М.СЭВЖИДМАА

Б.ЭНХЦЭЦЭГ

П.СҮНЖИДМАА



070233